



Хувь хүн, нийгэм, эрүүл мэнд, эдийн засгийн боловсролын бодлого

Боловсруулсан: 2021 оны 08 сар

Дахин хянах: 2023 оны 08 сар

Хэрэгжих хүчинтэй хугацаа: 2 жил

Шинэ Үе сургууль

2021 он

ХУВЬ ХҮН, НИЙГЭМ, ЭРҮҮЛ МЭНД, ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОВСРОЛЫН БОДЛОГО

ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай багц хууль, Бага дунд боловсролын сайжруулсан сургалтын цөм хөтөлбөр, Олон улсын бакалавратын болон Кембрижийн хөтөлбөрийн гарын авлагыг үндэс болгон боловсруулав.

УДИРТГАЛ

Шинэ Үе сургууль нь 6-18 насны сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохирсон сургалтын хөтөлбөрийг Үндэсний цөм хөтөлбөр болон Олон улсын IB хөтөлбөрт тулгуурлан хэрэгжүүлдэг. Сурагчдаа нийгэмдээ эерэг хувь нэмэр оруулдаг, эрүүл чийрэг, бие даан тасралтгүй суралцагч байхад хамт олноороо хичээн ажилладаг. Бид сурагчдаа дараагийн шатны сургуульд элсэн орох, амьдралд шаардлагатай ур чадваруудыг эзэмшүүлэхэд бүхий л чадлаараа хичээж, чанартай боловсрол олгохыг зорьдог.

АЛСЫН ХАРАА: Олон улсын жишигт нийцсэн сургууль болж, дэлхийн иргэнийг бэлтгэх

ЭРХЭМ ЗОРИЛГО: Өндөр ур чадвартай багш нарын арга туршлагад тулгуурлан суралцагчдад чанартай боловсролыг олгох замаар олон улсын бүрэн дунд боловсролын стандартыг хангасан мэдлэгтэй, бие даан амьдрах чадвартай, хүмүүнлэг, ёс зүйтэй иргэнийг төлөвшүүлнэ.

Олон улсын стандартыг хангасан мэдлэгтэй, бие даан амьдрах чадвартай, монгол өв соёлоо дээдэлдэг, хүмүүнлэг, ёс зүйтэй иргэнийг төлөвшүүлнэ.

УРИА: Шинэ цагийн мэргэдийг “Шинэ Үе”-ээс

ҮНЭТ ЗҮЙЛС:

- 1. Хүндэтгэл:** Бид хүүхдийн эрхийг дээдлэн, суралцагчид, тэдний эцэг эх, асран хамгаалагчдад хүндэтгэлтэй хандаж, эрүүл чийрэг, баяр баясгалантайгаар суралцахад нь ямагт санаа тавин дэмжиж, бие биеэ хүндлэн ажилладаг.
- 2. Ёс зүй:** Аливаа ажлыг дэг журам, эмх цэгцтэй, ёс журмын дагуу, үнэнч шударгаар, ёс зүйн зөрчил гаргахгүй гүйцэтгэх нь бидний амжилтын үндэс юм.

3. **Хамтын ажиллагаа:** Бид хамтран ажилласнаар хамгийн сайн үр дүн, ололт амжилтад хүрдэг гэдэгт итгэдэг. Бусад сургууль, байгууллага, хамт олноос байнга суралцаж, харилцан туршлага солилцон, мэргэжил мэдлэгээ дээшлүүлэхийн зэрэгцээ эцэг эхийн оролцоог ханган ажиллана.
4. **Хариуцлага:** Багш, ажилтан бүр ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь чанартай биелүүлж, аливаа үйлдэл, шийдвэр, гарах үр дагавар бүхэндээ хариуцлагатай ханддаг. Сурагч, эцэг эх, асран хамгаалагчид гэрээний эрх, үүргээ ухамсарлан чандлан биелүүлж, харилцан бие биенээ хүндэтгэдэг.
5. **Тасралтгүй суралцагч:** Өөрсдийн сонирхсон зүйлсээ лавлан асуух, судлан шинжлэх чадвартай, аливаа зүйлд тэмүүлэлтэй, үргэлж суралцаж, хөгжих чадвартай иргэдийг төлөвшүүлнэ. Үүний тулд багш өөрөө тасралтгүй суралцагч байж, сурагч бүрийнхээ онцлогт тохирсон сургалтын арга технологид суралцана.

ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА БАРИМТЛАН АЖИЛЛАХ ЗАРЧИМ

Сургууль алсын хараа, эрхэм зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах зүйлсийг үйл ажиллагаандаа баримтлан ажилладаг. Үүнд:

- Сурагчдын нас, сэтгэхүйн онцлог, сурах арга барилын ялгаатай байдлыг харгалзан сургалтын хөтөлбөрөө боловсруулдаг.
- Сурагчид болон ажилчдаа хувийн дээд амжилтаа ахиулахад нь үргэлж дэмждэг.
- Сургууль нь байгууллагын ажилчдынхаа хичээл зүтгэлийг цаг үргэлж үнэлж, урамшуулдаг.
- Манай сурагчид, багш, ажилчид бие биедээ хүндэтгэлтэй, тэгш, шударга харилцдаг.
- Багш, ажилчид, сурагчид маань шинийг эрэлхийлэгч, санаачлагчтай аливаа зүйлд ханддаг.
- Багш, ажилтан, сурагчдынхаа амжилтуудыг урамшуулан нийтэд таниулдаг.
- Хүн бүр өөрийн үүрэг хариуцлагыг дээд зэргээр ухамсарлан ажилладаг тул суралцах, ажиллах орчин ая тухтай, цэвэр цэмцгэр байдаг.
- Сургуулийнхаа дүрэм журам, бодлогын хэрэгжилтийг олон нийт болон эцэг, эхчүүдэд өөрийн веб хуудас болон фэйсбүүк хуудсаараа дамжуулан хүргэдэг.
- Сурагчид өөрт нь таагүй санагдсан, сэтгэл мэдрэмжээ илэрхийлэхийг хүсэх үедээ сургуулийн нийгмийн ажилтанд хандах боломжтой. /Хүүхэд хамгааллын бодлогоос дэлгэрэнгүй харах боломжтой./

- Их, дээд сургуульд элсэн орох, тэтгэлэгтэй суралцах талаар зөвлөгөө, чиглүүлгийг ахлах сургуулийн элсэлт хариуцсан мэргэжилтэнтэй уулзан зөвлөлддөг.
- Сурагчид маань сургуулиа төгсөхдөө хүүхэд нэг бүр багшийн тодорхойлолт, зорилго тодорхойлсон эсээ, хувь хүний онцлогоо харуулсан CV-тэй болж төгсдөг.

СУРАГЧДАД ОЛГОХ ЧАДВАР

Сурагчиддаа дараах чадваруудыг олгоход чиглэн ажиллаж байна. Үүнд:

- Ёс суртахуун, нийгэм соёлын талаарх ойлголттой болж хүн бүртэй хүн утгаар харьцах чадвар олгох
- Өөртөө итгэлтэй, үүрэг хариуцлагаа ухамсарлах
- Бусдын үнэт зүйл, зан заншил, соёлд хүндэтгэлтэй хандах
- Хүн бүр адил байх албагүй гэдгийг ойлгон бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх
- Сургуулийнхаа үйл ажиллагаа болон олон нийтийн арга хэмжээнд оролцохдоо бие даасан, хариуцлагатай, идэвхитэй байх
- Олон эх сурвалжид тулгуурлан үнэн зөв мэдээллийг олж аваад түүндээ өөрийн үнэлэлт дүгнэлт өгөх чадвартай байх
- Ардчилсан нийгмийн эерэг, идэвхтэй гишүүд болоход бэлэн байх
- Эрүүл, аюулгүй амьдралын хэв маягийг хөгжүүлэх
- Сэтгэл зүйгээ удирдах чадвартай байх
- Эрүүл, аюулгүй амьдралын хэв маягийг ойлгох, түүнийг амьдралдаа хэрэгжүүлэх
- Өөрийн болон бусдын эрх ашгийг зөрчих үг үйлдэл гарахад өөрийн үзэл бодлыг илэрхийлж нийгэмд эерэг өөрчлөлт оруулахад хувь нэмэр оруулах

Сурагчдынхаа нийгэм, соёл, эдийн засаг, бие махбодь, оюун санаа, мэдлэгийн ялгаатай байдлаас үл хамааран тэднийгээ өөрийнхөө хэмжээнд бүхий л чадлаа дайчлан суралцаж, хөгжих боломжийг бид олгодог. Ингэснээр тэд маань бүтээлч, идэвхтэй иргэн болж төлөвшдөг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН АЖИЛДАА БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Багш сурагчид маань хичээл сургалтын ажилдаа дараах зарчмыг баримталдаг. Үүнд:

- Идэвхтэй сургалтын арга зүйг хэрэглэдэг.
- Анги танхимд бүдүүлэг үг хэллэг хэрэглэдэггүй.
- Дуугаа өндөрсгөдөггүй.

- Хүмүүстэй санал нийлэхгүй байсан ч тэднийг хүндлэн харьцдаг.
- Санал бодлоо хүндэтгэлтэй эерэг байдлаар илэрхийлдэг.

ҮНЭЛГЭЭ

Багш нар сурагчдынхаа ахиц, амжилт төлөвшлийг үнэлэн, тэднийг урамшуулдаг. Багш, ажилтнуудын идэвх, санаачлага, ажлын үр дүнг сургуулийн захиргаанаас урамшуулдаг. Багш бүр өөрийн хөгжлийн төлөвлөгөөг бичин, мэдлэг боловсрол, харилцаа, хандлагадаа анхааран ажилладаг. Үүнийг өөрийн үнэлгээ болон сургуулийн үнэлгээгээр үнэлдэг.

ИЖИЛ БОЛОМЖ, ХҮРТЭЭМЖ

Арьс, өнгө, нас хүйс, шашин шүтлэг, бие эрхтний ялгаатай байдал, зэргээс үл хамааран сурагчид маань тэгш хүртээмжтэй, чанартай боловсролыг эзэмшдэг. Энэ талаар Тусгай хэрэгцээт боловсрол, Хөтөлбөр хэрэгжүүлэх журам, Хэлний бодлого зэргээс харах боломжтой.

ХАМААРАЛ БҮХИЙ БАРИМТ БИЧГҮҮД

- Хүүхэд хамгааллын бодлого
- Тусгай хэрэгцээт боловсролын журам
- Хөтөлбөр хэрэгжүүлэх журам
- Шалгалтын журам
- Хэлний бодлого

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО гудамж 12
Улаанбаатар хот, Монгол улс